

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	1
Хуралдааны товч тэмдэглэл:	2-5
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	6-27

1. Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025 оны 09 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	6-27
---	------

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны намрын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
10 дугаар сарын 23-ны өдөр /Пүрэв гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 32 гишүүнээс 18 гишүүн хүрэлцэн ирж, 56.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 40 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Баярмаа, Т.Доржханд, Ц.Идэрбат, Ч.Лодойсамбуу;

Чөлөөтэй: О.Алтангэрэл, Д.Амарбаясгалан, Л.Оюун-Эрдэнэ, О.Цогтгэрэл, Ө.Шижир, Л.Энх-Амгалан;

Эмнэлгийн чөлөөтэй: Л.Гантөмөр.

Нэг.Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025 оны 09 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Монгол Улсын Ерөнхий аудиторов орлогч З.Цэдэнжав, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал Д.Энхболд, Төрийн албаны зөвлөлийн дарга Л.Цэдэвсүрэн, Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга Д.Баянбилэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга Д.Ариунболд, Сонгуулийн ерөнхий хорооны тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, мөн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, Санхүү, төсвийн судалгааны газрын дарга Г.Золбоо, Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Санхүүгийн бодлогын газрын дарга С.Тулга, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Төсвийн орлогын хэлтсийн дарга Л.Ичинноров, Төсвийн зарлагын хэлтсийн дарга Д.Бат-Эрдэнэ, Өрийн удирдлагын хэлтсийн дарга Л.Гантогтох, Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга Ш.Бат-Эрдэнэ, Хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга Б.Ганзориг, Татварын ерөнхий газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Татвар хураалтын удирдлага, арга зүйн газрын дарга Р.Мягмаржав, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү, мөн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга Т.Баясгалан, Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Мөнхтөр, Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга П.Чандмань, Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Б.Урьболд, Төрийн захиргааны удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга Ж.Гэрэлбат нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын газрын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн, Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ц.Баянмөнх, референт О.Мөнгөнчавхдас, Төсвийн байнгын хорооны ажлын албаны зөвлөх Ё.Энхсайхан, референт С.Тэгшжаргал нар байлцав.

Төсвийн төслийг танилцуулгыг Монгол Улсын Сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Саранчулуун, А.Ариунзаяа, Д.Энхтуяа, Ц.Сандаг-Очир нарын тавьсан асуултад Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Бямбацогт, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд Б.Батбаатар, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа, Ц.Даваасүрэн, Ц.Сандаг-Очир нар үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналаар санал хураалт явуулав.

Ц.Сандаг-Очир: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой, “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/ хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 404,3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий Баян-Адарга сум/ хэрэгжих хугацаа 2026-2026 онд төсөвт өртөг болон санхүүжих дүн 404,3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 6
Татгалзсан: 14
Бүгд: 20
30.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой, Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179,7км /Хэнтий Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/ хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 186,000.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 434,1 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий Баян-Овоо сум/ хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 434,1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбатын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой, /Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/ хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 951,8 сая төгрөгөөр бууруулж, энэ эх

үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий Бэрх тосгон/ хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүнд 651,8 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 16
Бүгд: 21
23.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатарын гаргасан, Боловсрол, Эрүүл мэнд, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг 0,37 хувиар буюу 290,204.3 сая төгрөгөөр бууруулж, төслийн 2 дугаар хавсралтын УТ2603800007 төслийн кодтой, Сонгуулийн ерөнхий хорооны тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 41,720.4 сая төгрөг, санхүүжих дүн 12,516.1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг мөн дүнгээр нэмэгдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар үн хэлж, Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга Д.Бат-Эрдэнэ тайлбар хийв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагийн гаргасан, Төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж болох 36 хүртэлх сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмжийн зардалд тусгагдсан санхүүжилтийг 178,089.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, уг эх үүсвэрийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын бараа, үйлчилгээний бусад зардлыг 178,089.9 сая төгрөгөөр бууруулах замаар бүрдүүлэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяа гаргасан саналаа тайлбарлаж үг хэлэв.

Зөвшөөрсөн: 13
Татгалзсан: 8
Бүгд: 21
61.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн нарын гаргасан, Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100257 төслийн кодтой, төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем /Улаанбаатар Сүхбаатар дүүрэг/ хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,506.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 1 тэрбум 578 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 13
Бүгд: 21
38.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн нарын гаргасан, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн багцын урсгал зардал дахь Төрийн шагнал, одон медалийн зардлыг 1,842.9 сая төгрөгөөр бууруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 16
Бүгд: 21
23.8 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу, С.Цэнгүүн нарын гаргасан, Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын урсгал зардал дахь Эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардлыг 204 тэрбумаар бууруулах гэсэн санал нь Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний асуудал биш тул санал хураалт явуулаагүй болно.

9.Улсын ИХ Хурлын гишүүн Б.Пүрэвдоржийн гаргасан, Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын урсгал зардлаас 300.0 сая төгрөгийг бууруулж, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлын төлбөр хураамжийг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх гэсэн санал нь Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээний асуудал биш тул санал хураалт явуулаагүй болно.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн Төсвийн байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 07 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 1 цаг 27 минут үргэлжилж, 32 гишүүнээс 21 гишүүн хүрэлцэн ирж, 65.6 хувийн ирцтэйгээр 12 цаг 07 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ
ХЭЛТСИЙН ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2025 оны 10 дугаар сарын 23-ны өдөр, Пүрэв гараг
Төрийн ордон “Их засаг” танхим
10 цаг 40 минут.

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсэгт заасны дагуу хуралдааны ирцийг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанд Аюушийн Ариунзаяа, Мягмарсүрэнгийн Бадамсүрэн, Жадамбын Бат-Эрдэнэ, Батын Батбаатар, Баярмагнайн Баярбаатар, Сандагийн Бямбацогт, Амгаланбаатарын Ганбаатар, Сархадын Зулпхар, Лхагвын Мөнхбаатар, Чинбатын Номин, Эрдэнэбилэгийн Одбаяр, Бөхчулууны Пүрэвдорж, Цэндийн Сандаг-Очир, Отгоны Саранчулуун, Цэвэгдоржийн Туваан, Гончигдоржийн Уянгахишиг, Бадарчийн Хэрлэн, Доржзовдын Энхтуяа нарын гишүүд хүрэлцэн ирсэн байна. Байнгын хорооны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Өнөөдрийн хуралдаанаар Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг санал, дүгнэлтээ Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ/.

Хэлэлцэх асуудлаар саналтай гишүүн байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2025 оны 9 сарын 1-ний өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/-ийг хийнэ.

Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд оролцож байгаа албан тушаалтнуудыг танилцуулъя. Дуудаарай. Ажлын хэсгийнхнийг дууд. Засгийн газрынхнаас хэн танилцуулах юм. Та танилцуулах юм уу. Материалаа танилцуулахгүй юм уу. Танилцуулга хийх ёстой доо. Ажлын хэсэг Учрал сайд байхгүй байна. Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга байна уу. Т.Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга байна уу. Эдийн засаг, хөгжлийн яамныхан хэрэгтэй юм уу, хэрэггүй юм уу. Энэ 3 дахь хэлэлцүүлэг дээр. 5, 6 албан тушаалтан байх ёстой юм байна. 6-уулаа байхгүй байгаа юм уу. Мөнхтөр, Чандмань, Урьболд, Гэрэлтбат.

10 цагаас хурал зарлагдсан, 42 минутын дараа хуралд ажлын хэсгийнхэн ирээгүй байж байх юм. Сангийн яамнаас Ж.Ганбат Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга байна уу. Үгүй ээ, энэ төсвөө хэлэлцүүлэх юм уу, хэлэлцүүлэхгүй юм уу. Төсвийг нь хэлэлцье гэж байхад Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамныхан нь байхгүй болохоор чинь тэгээд бид нар юугаа хэлэлцэх юм. Санжаадорж байна уу. Өөр Байнгын хороон дээр байгаа юм уу. Өөр давхардаж байгаа Байнгын хороо байгаа юм уу. Байхгүй байна. Тэгээд ямар учир шалтгаанаар асуудал хэлэлцүүлэх гээд байхад чинь орж ирэхгүй байгаа юм бэ. Тэгээд бид нар гуйж хэлэлцүүлэх юм уу энэ төсвийг нь. Золбоо Сангийн яамны Санхүү, төсвийн судалгааны газрын дарга, Тэлмүүн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Тулга Сангийн яамны Санхүү бодлогын газрын дарга. Ирээгүй хүмүүсийг тэгээд дуудах юм уу, яах юм. Энд байгаа хүмүүс чинь байгууллагын дарга нар байна уу. Алив хурдан дууд л даа. Эдийн засаг, хөгжлийн яамныхан орж ирж байна уу. Энх-Амгалан дарга байна уу. Л.Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга, Баясгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга, Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Чандмань Эдийн засаг, хөгжлийн яамны Тогтвортой хөгжил, нийгмийн бодлогын хэлтсийн дарга, Урьболд Эдийн засаг, хөгжлийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга, Гэрэлбат Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргаа, удирдлагын газрын Санхүүгийн хэлтсийн дарга, Сангийн яамныхан орж ирсэн үү. Сангийн яамныхан хэн нь ирсэн байна. Сангийн яамнаас. Дэлгэржаргал дарга Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга. Чимэдсүрэн Татварын ерөнхий газрын дарга ирсэн байна. Гантогтох дарга байна уу. Өрийн удирдлагын газрын дарга Сангийн яамны хэлтсийн дарга. Өөр хэн хэн байна. Энэ олон хүмүүс дотроос хэн нь ирсэн юм. Сангийн яамныхан хаана байгаа юм. Бүгд ирчихсэн гэж. Сангийн яамныхныг түр азнаад, Цэнджав Монгол Улсын Ерөнхий аудиторовын орлогч. Д.Энхболд Үндэсний Аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, Баттуяа Үндэсний Аудитын Газрын Нийцлийн аудитын газрын захирал. Ерөнхийлөгчийн Тамгын газраас Ганболд Ерөнхийлөгчийн Хот, хөдөөгийн бодлого хариуцсан ахлах зөвлөх. Энд орох юм уу. Ерөнхийлөгчийн Тамгын газраас. Улсын Их Хурлын Тамгын газраас Лхагвасүрэн Улсын Их Хурлын Тамгын газрын Менежментийн газрын Санхүү, хангамж үйлчилгээний хэлтсийн дарга байна уу. Аль байна. Засгийн газрын Хэрэг эрхэх газраас Бямбасүрэн дарга байх ёстой юм уу. Ж.Бямбасүрэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга, Л.Цэдэвсүрэн Төрийн албаны зөвлөлийн дарга байна. Баянбилэг Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын дарга байна. Ариунболд Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын албаны дарга байна. Д.Бат-Эрдэнэ Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга байна. Батбаатар Стандарт хэмжилзүйн газрын дарга байна уу. Мөнхжаргал Бүсчилсэн хөгжлийн үндэсний хүрээлэн Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын төлөвлөлтийн газрын дарга байна уу. Байна. Х.Сүхбаатар Шадар сайдын ажлын албаны референт байна. Оюунцэцэг Шадар сайдын зөвлөх. Сангийн яамныхнаас нэмэгдсэн үү. Хэн хэн ирчхэв. Ганбат дарга ирсэн үү. Санжаадорж дарга ирсэн үү. Золбоо дарга ирсэн үү. Тэлмүүн дарга ирсэн үү. Золбоо дарга, Тэлмүүн дарга ирсэн байна. Тулга дарга ирсэн үү. Санхүүгийн бодлогын газрын дарга, Дэлгэржаргал дарга ирсэн. Ичинноров дарга ирнэ үү. Байна уу. П.Бат-Эрдэнэ Зарлагын хэлтсийн дарга байна, Ш.Бат-Эрдэнэ Сангийн яамны Хөрөнгийн удирдлагын хэлтсийн дарга, Ганзориг Сангийн яамны хөгжлийн санхүүжилтийн хэлтсийн дарга байна. Ингээд үндсэндээ ажлын хэсгийнхнийг танилцуулж дууслаа.

Одоо Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн танилцуулгыг Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Сангийн сайд Болдын Жавхлан танилцуулна. Жавхлан сайд байгаа юм уу. Байхгүй байна шүү дээ. Хэн танилцуулах юм.

Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд төсвийн танилцуулгыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын Засгийн газрын гишүүн Сандагийн Бямбацогт танилцуулна.

С.Бямбацогт: Байнгын хорооны гишүүдийн өдрийн амгаланг айлтгая. Монгол Улсын Засгийн газраас Монгол Улсын 2026 оны төсвийн төслийг боловсруулж, 2025 оны 9 сарын 1-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн билээ.

Ирэх 2026 оны төсвийн төслийг Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөтэй уялдуулан боловсрууллаа.

Төсвийн төсөлд туссан тус Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарах онцлох арга хэмжээг дурдвал,

1 дүгээрт төсвийн урсгал зардлын хувьд удирдах албан тушаалтны орон тоог бууруулж, төрийн албан хаагчдын нийт орон тооны тэлэлтийг хязгаарлахын зэрэгцээ төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төсвийн байгууллагын үр ашиггүй зардлыг бууруулан, хэмнэгдсэн хөрөнгийг нийгмийн салбарт зарцуулах, экспортыг нэмэгдүүлэх, уур амьсгалын өөрчлөлт, дасан зохицоход чиглэсэн арга хэмжээний зардал буюу геологийн судалгаа, эрлийн ажлын зардал, хүн амын хүнсний хэрэглээний улаан буудайн нөөц бүрдүүлэх зардал, байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал, гамшиг ослын үеийн бэлэн байдлыг хангах, албан хаагчдын орлогын баталгааг сайжруулахад шаардлагатай зардлыг санхүүжүүлэх,

Сүүлийн жилүүдэд дэлхийн уур амьсгалын өөрчлөлт бүс нутгийн хэт халалт, гандуу нөхцөл, зуд зэрэг байгалийн гамшгийн давтамж нөлөөлөл нэмэгдэж байна. Монгол Улсад 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх эрсдэлтэй байгаа бөгөөд болзошгүй бусад гамшиг осол зэргийг харгалзан Засгийн газрын нөөц сан, аймаг сумдын Засаг даргын нөөц хөрөнгийг нэмэгдүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46.1-д Эрүүгийн хуульд заасны дагуу оногдуулсан торгох ял, Зөрчлийн тухай хуульд заасны дагуу зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг биелүүлж, төсөвт төвлөрүүлсэн мөнгөн дүнгийн 40-өөс доошгүй хувийг дараагийн жилийн төсөвт тусгаж санхүүжүүлэхээр заасан.

Энэ хүрээнд урьдчилан тооцоолсноор 2025 оны Эрүүгийн хууль болон Зөрчлийн хуулийн тухай хуулийн хүрээнд төсөвт төвлөрөх торгуулийн орлогын 40 хувийг орон нутгийн суурь зардалд тусгалаа. Ингэснээр судалгаа шинжилгээ, шинжлэх ухаан, техник технологийн орчин үеийн ололтод үндэслэж гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг үр өгөөжтэйгөөр зарцуулсны үр дүнд нийгмийн хэв журам сайжирч, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, улмаар гэмт хэрэг, зөрчлийн тоо хэмжээ буурах, иргэдийн амар тайван амьдрах орчин бүрдэх ач холбогдолтой юм.

Санхүүгийн арга хэмжээ авах байгууллага ФАТФ-аас 2027-2029 онд хийх харилцан үнэлгээнд бэлтгэх хүрээнд Монгол Улс мөнгө угаах болон терроризмыг санхүүжилттэй тэмцэх тогтолцооны хэрэгжилт, үр дүнтэй байдлыг сайжруулах чиглэлээр шат дараатай арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Үүнд, эрсдэлд суурилсан хяналт шалгалтын үр дүнг нэмэгдүүлэх, шинэ технологийн хэрэглээнээс үүдэх эрсдэлийг бууруулах бодлого боловсруулах, олон улсын туршлага, техник хэрэгсэл, программ хангамжийг судлан нэвтрүүлэх, гэмт хэрэг илрүүлэх арга барилыг шинэ түвшинд хүргэх зэрэг ажлууд багтаж байна.

Мөн Монгол Улсын олон улсын өмнө хүлээсэн үүрэг болох ФАТФ-ын зөвлөмжийн хэрэгжилтийг хангах зорилгоор тусгай чиг үүргийн байгууллагуудын үйл ажиллагаанд шаардах зардлыг тус тус 2026 оны улсын төсвийн төсөлд тусгалаа.

2 дугаарт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг хуульд заасны дагуу 2025 оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн иргэдээс санал авч, сум, дүүрэг, аймаг, нийслэл, салбар яамдын түвшинд үе шаттайгаар төлөвлөсөн.

Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр нийт 14,4 их наяд төгрөгийн санхүүжих дүн бүхий 1712 төслийн санал хүлээн авснаас холбогдох шалгуур үзүүлэлт, зарчим, бодлогыг харгалзан эрэмбэлж, 579 төсөл арга хэмжээнд 3 их наяд 267 тэрбум төгрөг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан болно.

Нийт хөрөнгө оруулалтын 67 хувь буюу 2 их наяд 181 тэрбум төгрөг нь үргэлжлэн хэрэгжих бол, 33 хувь буюу 1 их наяд 85 тэрбум төгрөг нь шинээр хэрэгжих хөрөнгө оруулалт байна. Энэ нь 2022-2023 онд батлагдсан төсвийн тоотой харьцуулахад 2 дахин буурсан үзүүлэлт бөгөөд төслийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, үнэлэх, эрэмбэлэх шалгуур үзүүлэлтийн чанар сайжирч байгааг илтгэж байна. Түүнчлэн 2026 оны төсвийн хөрөнгө оруулалтад хүний хөгжлийг дэмжих зорилгоор боловсрол, эрүүл мэндийн салбарт бүсчилсэн хөгжил болон хувийн хэвшлийг дэмжиж, бизнесийн орчныг сайжруулах хүрээнд эрчим хүч, суурь дэд бүтцийн салбарт гамшгийн эрсдэлийг бууруулж үндэсний сөрөн тэсвэрлэх чадавхыг нэмэгдүүлэх зорилгоор онцгой байдлын салбарт нийгмийн хэв журам, аюулгүй байдлыг хангах үүднээс батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбарт шинэ хөрөнгө оруулалтыг түлхүү төлөвлөлөө.

Тухайлбал, тус Байнгын хороонд хамаарах салбар болон байгууллагууд буюу Монгол Улсын Ерөнхийлөгчийн багцад 500 сая төгрөг, Улсын Их Хурлын даргын багцад 3,6 тэрбум төгрөг, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын багцад 40 тэрбум төгрөг, Монгол Улсын Шадар сайдын багцад 50 тэрбум төгрөг, Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын багцад 26 тэрбум төгрөг, Монгол Улсын Ерөнхий аудиторовын багцад 2,5 тэрбум төгрөг, Сонгуулийн ерөнхий хорооны даргын багцад 12,5 тэрбум төгрөг, Төрийн албаны зөвлөлийн даргын багцад 435 сая төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан.

Мөн олон улсын өмнө хүлээсэн үүргийн хүрээнд НҮБ-ын Коп-17 хурлыг зохион байгуулахад шаардагдах санхүүжилт болон гадаад зээл, тусламжийн төслүүдийн Монголын талын хариуцах хөрөнгийг төсөвт тусгалаа.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2026 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 31,6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь зардал 29,6 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн суурь тэнцэл 2 их наяд төгрөгийн ашигтай буюу ДНБ-ий 2 хувь байж төсвийн тусгай шаардлагуудыг бүрэн хангахаар байна.

Иймд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Бямбацогт сайдад баярлалаа. Улсын Их Хурлын гишүүн А.Ариунзаяагаас Төрийн байгуулалтын байнгын хорооны 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаан дээр төрийн албан хаагчдад өндөр насны тэтгэвэрт гарахад 36 хүртэлх сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний 1 удаагийн тэтгэмж олгоход шаардлагатай зардлыг 2026, 2027 онд хуваан олгохоор төсвийн төсөлд тусгасан нь Төрийн албаны тухай хууль болон Төсвийн тухай хуульд нийцэж буй эсэх талаар Улсын Их Хурлын Тамгын газраас зөвлөмж гаргуулах хүсэлт гаргасны дагуу Тамгын газраас ирүүлсэн зөвлөмжийг бас гишүүдэд тараасан байгаа гэдгийг хэлчихье.

Одоо ингээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.3-д Байнгын болон дэд хорооны хуралдаанд гишүүд Байнгын, дэд хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно гэж заасан. Ингээд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх Бямбацогт сайдын танилцуулга болон Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асуух гишүүн байна уу. Нэрсээ өгнө үү. Саранчулуун гишүүнээр, Батын Батбаатар гишүүнээр тасаллаа. Ариунзаяа гишүүн асуултаа асууя. Ирцээрээ Саранчулуун гишүүн асуултаа асууя.

О.Саранчулуун: Ганцхан асуулт асуучихъя. 2025 оны 6 сарын 2-ны Монгол Улсын Сангийн сайдын тушаал 112 дугаар тушаал байгаа. Энэ тушаал дотор төсвийн зарим ангиллыг шинэчлэн батлах тухай гэж байна. Энэ дээр Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын 1 дүгээр, төсвийн зарлагын эдийн засгийн ангиллын тайлбарыг 2 дугаар, зардлын зориулалт болон арга хэмжээний ангиллыг 3 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай гэсэн байна. Энэ зардлын ангилал дотор миний удаа дараа асууж байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүн болон хүртээмжтэй холбоотой зардлын ангиллууд тун тодорхой бус бүрхэг тусгагдаад байгаа байхгүй юу. Тэгэхээр энийг хэзээ энэ ангиллыг жил болгон шинэчилдэг юм уу эсвэл гишүүд санал өгөөд шинэчилдэг юм уу. Энэ дээр би хариулт авъя.

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүний асуултад хэн хариулах вэ. Хэн хариулах вэ. Сангийн яам Төрийн нарийн бичгийн дарга Ганбат. Ажлын хэсгийн хэд дүгээр микрофон бэ. Индэр дээрээс хариулах юм биш үү. Эсвэл энэ дугаартай микрофонууд дээр суух юм байна. Алив 4 дүгээр микрофон дээр суулгачих. Ажлын

хэсгийн 4 номерын микрофон. Асуулт асуух гишүүнд Доржзовдын Энхтуяа гишүүнийг нэмчхээрэй. Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Ж.Ганбат: Гишүүний асуултад хариулъя. Ер нь бол бид төсвийн эдийн засгийн ангиллыг бол Сангийн сайдын тушаалаар батлуулдаг. Тэгэхдээ яг Улсын Их Хуралд бид төсөв өргөн барихдаа бас дэлгэрэнгүйгээр эдийн засгийн ангиллыг ер нь дэлгэрэнгүй хийж байгаа. Өнгөрсөн жилийн төсөв Улсын Их Хурлаар хэлэлцэх явцад бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ гэдэг зардлын зүйл ангиллыг тодорхой болгох гэдэг ийм чиглэлийг Улсын Их Хурлаас өгсөн. Энэ хүрээнд бид ер нь төсвийн зардлын ангиллыг аль болох дэлгэрэнгүй байдлаар батлаад явах нь зүйтэй гэдэг ийм байдлаар үзээд, энэ 2026 оны төсвийн төслийг боловсруулахдаа бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ гэдэг зардлын ангиллыг бол аль болох дэлгэрэнгүй байдлаар ингэж оруулсан. Ер нь Сангийн яам бол нөгөө зардлын ангилал энэ тэр, ер нь бол бүх юм уялдаатай байгаа. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, шилэн данстай холбоотой аль болох ил тод нээлттэй байлгах зорилгоор эдийн засгийн ангиллыг бид аль болох дэлгэрэнгүй байдлаар батлуулахыг бол зорьж байгаа. Тэгээд яах вэ, яг улсын хэмжээний эдийн засгийн ангиллыг батлахад төсвийн ерөнхийлөн захирагч нар дээр гарч байгаа зарим зардлын зүйлүүдийг бас нэгтгэж барих, зарим байгууллагууд нийтлэг байдлаар байгаа учраас энэ дээр бол бид сая ингэж батлуулсан байгаа. Сангийн яамнаас бид дахиад зардлын эдийн засгийн ангилал дээр би бол сайжруулах тал дээр бид ажлын хэсэг байгуулаад ажиллаж байгаа. Энэ дээр бол ОУВС-ийн баталсан стандарт байдаг. Бүх оронд мөрддөг. Үүний дагуу нарийвчилж батлуулахаар ажиллаж байгаа. Үүнийг бид энэ намар Сангийн сайдын тушаалаар батлуулаад, ирэх жилийн төсөв дээр илүү нарийвчилж оруулна гэж үзэж байгаа.

Ц.Сандаг-Очир: Саранчулуун гишүүн тодруулга 1 минут.

О.Саранчулуун: Нэгд нь зардлын ангиллын төсвийн зарим ангилал шинэчлэн батлах тухай энэ тушаал дээр та хэд олон улсын конвенцыг хардаг юм уу гэдэг асуулт байна.

2-т гэвэл жишээ авъя. Би ганцхан зардлыг асууя. 802240 кодтой зөвлөл, хороо, комиссын гишүүдийн ажлын хөлс бүх яамд гэж байна. Энд нийт улсын төсвөөс ямар зардал гардаг юм гэдгийг хариулчих.

Гуравдугаарх нь хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөл яам болгоны дэргэд байдаг. Хурал болгоноор хуралдаад Сангийн яаманд үргэлж ийм ийм зүйлийг анхаараач гэж удаа дараа хэлсэн асуудлууд байгаа. Тэдгээрийн санал, зөвлөмжийг яагаад энэ зардлын ангилалдаа оруулаад, саяхан баталсан байна шүү дээ. 2025 оны 6 сард баталсан байна шүү дээ. Тэгэхэд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн яамны дэргэдэх зөвлөл чинь бараг 2, 3 жилийн турш ярьж байгаа асуудал шүү дээ. Яагаад эд нарын асуудлыг өнөөдөр оруулаад, энэ зардалдаа хэлэлцэж болдоггүй юм бэ гэдгийг дахиад асуучихъя.

Ц.Сандаг-Очир: Ганбат дарга. Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Ж.Ганбат: Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар бүх яамнууд дээр Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үндэсний зөвлөлийн салбар хороод зөвлөл гэж байгаа. Энэ Төрийн нарийн бичгийн дарга нараар ахлуулсан. Энэ бол нэлээн идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг. Үүнтэй холбоотой хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой зардал энэ тэрийг оруулахаар

Сангийн яам дээр энэ талаар чиглэл өгөөд, бүх яамнууд дээр уг нь үүнтэй холбоотой ингэсэн.

Нөгөө талдаа бид бас ийм зарчим барьж байгаа гишүүн ээ. Яах вэ, яг энийг хэрэгжүүлэх явцад зарим яамнууд дээр бүр тусдаа зардлын ангилал гаргаж өгөөч энэ тэр гээд асуудлууд яригдаад, тусдаа төсөв нэхсэн асуудлууд байгаа. Жишээ нь бид бол энэ дээр төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдөө төсөв дотроо багтаагаад, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төрийн үйлчилгээг үзүүлэх ийм үндсэн үүрэгтэй учраас энийг бол хэрэгжүүлээд явах бүрэн бололцоотой гэдэг ийм байдлаар үзэж байгаа. Бас энэ дээр бид илүү нарийвчилж, яг төсөв дээр энэ ангиллыг оруулаад, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тусгайлан зардлын зүйлээр эхнийх нь байдлаар хийгээд явж байгаа юмнууд бол байгаа. Гэхдээ энэ дээр бид бас илүү нарийвчилж, тодорхой болгож оруулахгүй бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан үйлчилгээнүүдийг бас юу гэдэг юм тохижилт энэ тэр гэдэг дээр бас их хэмжээний мөнгө нэхэж байгаа газрууд бол сая төсөв боловсруулах явцад үүсэж байсан л даа. Тэгээд бид энэ дээр нэгдсэн стандарт, олон улсын тэр ангиллын дагуу зардлын зүйлүүд дээр бас гаргаад, нэгдсэн байдлаар бас тодорхой чиглэл өгөөд ингээд ажиллаж байгаа.

Ц.Сандаг-Очир:Ариунзаяа гишүүн асуултаа асууя.

А.Ариунзаяа: Өглөөний мэнд хүргэе. Намайг хууль ярихаар чи хууль тайлбарлахгүй гээд бөөрөлхөөд байдаг учраас би Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийнхээ дагуу Байнгын хороо дээрээ санал, хүсэлт гаргаад, тэгээд Байнгын хорооноос албан ёсоор шийдвэр гарч, хууль зүйн албан ёсны дүгнэлт үнэлгээ өгөх ийм хүсэлтийг гаргаад, хууль зүйн зөвлөмж, үнэлгээнүүд ирсэн байна. Тэгээд гишүүдэд тараагдсан байгаа. Чуулган дээр ч гэсэн тараагдах байх.

Төрийн албан хаагчдын өндөр настны тэтгэвэрт гарахад олгодог 36 сарын тэтгэмжийг 36 сар хүртэл гэж байгаа шүү дээ энэ чинь. Бүтэн 36 бич биш. Хэдэн жил ажилласнаас хамаарч 36 сар хүртэл тэтгэмж олгогддог. Улс төрийн албан хаагчдад олгогддоггүй. Энэ бол зөвхөн улс төрийн төрийн албан хаагчдаас бусад албан хаагчдад хуулиараа олгогдох ёстой тэтгэмжийн 50 хувийг нь олгохгүй буюу эх үүсвэрийнх нь зөвхөн 50 хувийг тавьсан нь Төрийн албаны тухай хуулийн 9.2 болон Төсвийн тухай хуулийг ч гэсэн зөрчсөн байна. Эрх зүйн үр дагавартай байна гэдэг ийм хууль зүйн зөвлөмжийг өгсөн байна.

Төрийн албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгтэй зөрчил үүсгэхээр байна. Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт болон 70 дугаар зүйлийн 70.5 дахь хэсэгтэй зөрчил үүсэх учраас Төсвийн хууль хуульд нийцэж гарах үүрэгтэй гэж үзэж, энэхүү төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гаргахад төрөөс олгогдох энэ тэтгэмжийг 100 хувь төсөвт нь суулгах ёстой гэдэг энэ үүргийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Тэгэхээр үүнд бол 178 тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай. Тэгэхээр энэ мөнгийг хаанаас гаргах боломжтой байна вэ гэдгийг Сангийн яам бас эртхэн шиг хэлчихвэл уг нь зарчмын зөрүүтэй саналаа гаргахдаа зөв гаргаад томьёоллыг нь гаргачихмаар байгаа юм. Одоогийн байдлаар би хуулийн хугацаандаа шахагдаад Байнгын хороонд зарчмын зөрүүтэй саналаа ирүүлэхдээ нийт төсвийн ерөнхийлөн захирагчдын урсгал зардлын бараа, үйлчилгээний зардлын бараа, үйлчилгээний бусад зардал зэрэг энэ ангиллаас нийтээр 6 хувь бууруулаад мөн түүнчлэн Коп-ын зардлын байр байшин шинээр барих зардлын 35 тэрбум төгрөгийг бууруулах ийм саналыг гаргачхаад байгаа. Ер нь бол Коп бид нар Монгол Улсдаа хийж байгаа нь сайн боловч бусад улс орны

өмнө заавал баян харагдах гээд хэрэггүй шүү дээ. Тэгээд зуны дэлгэр цагт хийж байгаа бол тэгээд асар, майхандаа хийгээд үйл ажиллагаагаа аль болох бага зардалтай явуулчих бүрэн боломжтой. Бусдын өмнө баян болж жүжиглээд яах вэ дээ хэдүүлээ. Нөхцөл байдал хүнд байгааг бүгдээрээ мэдэж байгаа учраас энэ шинэ байр байшин барих энэ зардлыг бууруулах боломжтой гэж үзсэн учраас энэ саналаа гаргасан.

Тэгээд би Ганбат даргаас 178 тэрбум төгрөгийг өөрөөр .../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Ж.Ганбат: Энэ 36 сартай холбоотой Засгийн газар төсөв өргөн мэдүүлэхдээ бид төсвийн боломжтойгоо уялдуулан тавьсан. Өмнөх жилүүдийн практик дээр 2017, 2018 онуудад бид аль болох тэтгэвэрт гарах тэтгэмж дээр тухайн байгууллагын төсвийн ерөнхийлөн захирагч нар салбар дотроо зардлын зөвлөл хоорондоо зохицуулалт хийх байдлаар эхний ээлжид тэтгэвэрт гарах хүмүүсийн мөнгийг гарах ийм боломж байдаг. Ийм арга хэмжээнүүдийг бас авч хэрэгжүүлэх, тэтгэвэрт гарах хүмүүс нь дараа жилүүдэд бас өөрсдийнх нь хүсвэл үргэлжлүүлэн ажиллах гэдэг ийм байдлаар зохицуулж байсан практикууд бол байгаа юм. Бид бол одоо энэ төсвийн ерөнхийлөн захирагчдын ирүүлсэн энэ санал дээр үндэслэн төсвийн төслөө боловсруулахдаа бас яг эндээ багтаагаад энэ дүндээ хүмүүсийг тэтгэвэрт гарах асуудлаар зохион байгуулаач, төсөв батлагдсаны дараа төсвийн жил эхлээд хэрэгжилтийн явц дундаа зардлын зүйл хоорондоо төсвийн хэмнэлттэй байх зарчмаар өр, авлага үүсэхгүй байх зарчмыг үндэслэн энийгээ зохицуулах байдлаар ингэж яваач ээ гэдэг ийм байдал дээр үндэслэж, төсвийн төслийг бол боловсруулж өргөн барьсан байгаа. Түүнээс биш бид нар 36 сарыг хувааж өгнө энэ тэр гэдэг тийм байдлаар биш үзсэн байгаа. Зүгээр энэ тэтгэвэрт гарахад олгох 1 удаагийн мөнгөн тэтгэмжийг Төсвийн тухай хуулийн 41.2.2-т заасны дагуу баталсан төсвийн хүрээндээ бол зохицуулах, Төсвийн тухай хуулийн 6.4.8-д заасны дагуу төсөв хоорондоо зохицуулах байдлаар тэтгэвэрт гарч байгаа, өөрөө хүсээд мөнгөн тэтгэмжээ аваад гаръя гэж байгаа хүмүүсийн асуудлыг төсөв хоорондоо зохицуулаад явах бүрэн бололцоотой гэдэг ийм байдлаар боловсруулж өргөн барьсан байгаа.

Ц.Сандаг-Очир: Ариунзаяа гишүүн тодруулъя.

А.Ариунзаяа: Яах вэ, би таныг яаж өргөн барьсныг чинь бол ойлгоод байгаа юм. Гагцхүү би бол хуулиа барьж, хуулиа хэрэгжүүлье л гэж байгаа юм. Тэгээд 178 тэрбум төгрөгийн миний гаргасан зарчмын зөрүүтэй саналаас өөрөөр та нарт орон зай байгаа юу гэдгийг л мэргэжлийн хүнээс асууж байгаа юм. Тэгээд миний гаргасан зарчмын зөрүүтэй саналаар бид санал хураагаад явна. Тэгээд энэ дээр бас гишүүдийг Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хуулийг бас зөрчихгүй байх энэ нөхцөлийг хангаж, миний гаргаж байгаа зарчмын зөрүүтэй саналыг бас дэмжиж өгөөсэй. Төрийн албан хаагчид маань бас харж байгаа шүү гэдгийг хэлмээр байна.

Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт орсон нь бол та бүхний өмнө нь аргалж болж байсан зүйл, заалтыг байхгүй болгосон. Төсвийн тухай хуулийн 70 дээр тухайлсан төсвийн захирагч тухайн жил батлагдсан төсвийг зохистой удирдаагүйн улмаас өр, авлага үүсгэх юм бол өөрөө албан тушаалаасаа чөлөөлөгдөх ийм эрх зүйн үр дагавартай. Тэгэхээр хэдийгээр Ганбат дарга ч юм уу, Сангийн сайд ч юм уу, болно хэдүүлээ, зүгээр болно шүү дээ гэж.../минут дуусав/

Ц.Сандаг-Очир: 1 минут. Сүүлчийн 1 минут.

А.Ариунзаяа: Хэдийгээр Сангийн яам болчихно шүү дээ. Тэгээд өмнө нь ингээд ирсэн юм гэж хэлж байгаа боловч нөгөө талдаа яг үр дагаврыг үүрэх хүмүүс нь бол тухайн ерөнхийлөн захирагчид, төсвийн ерөнхийлөн захирагчид юм. Ийм учраас хэдүүлээ тэр хүмүүсийг эвгүй байдалд 1 дүгээрт оруулж болохгүй. 2 дугаарт энэ тэтгэвэртээ гарахыг хүлээж байгаа төрийн албан хаагчид бол бүтэн жил дахиад хүлээх, мөн дээрээс нь өнөөдөр ер нь ажил дээрээ үлдэх үү, үгүй юу, тэтгэврийн нас нь хүрэнгүүт 10 хувиар төрийн албыг цомхотгох энэ бодлогод бас орчих гээд байгаа, шахагдаад байгаа маш олон гэмгүй төрийн албан хаагчид байгаа учраас энэ дээр нь Улсын Их Хурлын гишүүд бид л анхаарч, яг төсвийг нь тавьж өгөхгүй бол болохгүй. Ер нь төрд итгэх итгэл үнэхээрийн та бидний энэ үйл ажиллагаанаас болж буурч байгаа дээр хэдүүлээ бас анхаарах ёстой гэдгийг л хэлье дээ. Дэмжиж өгөөрэй.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа. Батын Батбаатар гишүүн асуултаа асууя.

Б.Батбаатар: Сая Ариунзаяа гишүүн ярилаа, ерөнхийдөө асуулаа. Тэтгэвэр авагчид энэ 36 сарын энэ зүйлүүдийг тавих нь бол зүйтэй. Энэ санааг нь бол хуулийн дагуу ч санаа. Энийг нь дэмжиж байгаа. Гэхдээ одоо яг 297 хоногийн дараа Улаанбаатарт Коп-17 эхэлнэ. 297 хоног үлдэж байна. Хэдэн сар нь өвөл билээ Монгол Улс чинь өөрөө. Энэ арга хэмжээ Коп-17-г хийх арга хэмжээг илүү бага зардлаар, илүү зохион байгуулалттай хийх боломж байсан уу гэвэл байсан. Одоо цаг хугацааны хувьд бол боломж байхгүй. Энэ газрыг нь координатыг нь өөрчлөх боломжгүй болсон. НҮБ-ын Конвенцын газрын нарийн бичгийн албатай гэрээ хэлэлцээрээ зурчихсан. Монгол Улсын Засгийн газар хэлэлцээрээ хийчихсэн. Тийм болохоор Ариунзаяа гишүүнийг саяын Сангийн яамнаас асуугаад байгаад Сангийн яамныхан хариулбал их зүйтэй байна. Эх үүсвэрийг нь өөрчлөөч ээ. Коп- 17-оос 35 тэрбум авчихвал бид нар Коп-ыг хийх юм уу, үгүй юм уу. Өөр Их Хурлын гишүүд бас зөндөө саналууд гаргаж байна гэж ойлгосон.

1961 онд НҮБ-ын гишүүн улс орон боллоо. Бид нар тусгаар тогтнолоо бүрэн баталгаажууллаа гээд улсаараа баярлаж байсан гэдэг. Коп энэ цөлжилтийн конвенц чинь 197 улс хамтарсан байдаг. Монгол Улсын газар нутгийн 77 хувь нь цөлжилтөд өртсөн байдаг. Өмнөх копуудын жишээгээр аваад үзэхэд хурал зохион байгуулахад оруулсан хөрөнгө оруулалт, зардлаа багадаа 20 дахин буюу түүнээс дээш хэмжээгээр хөрөнгө оруулалт бий болдог. 500 сая доллар оруулаад 12 тэрбум доллар олж байна. Өмнөх нь 2,5 тэрбум доллар олж байна. Ийм хэмжээний хөрөнгө оруулалт ийм зүйл орж ирдэг. Бид нар энэ байгалийн хууль бол анхдагч хууль. Тийм болохоор энэ цөлжилтийн буюу Коп-17 талуудын бага хурлыг зохион байгуулах энэ эх үүсвэр, энэ төсөв дээр тавигдаж байгаа мөнгөнөөс Их Хурлын гишүүд минь эх үүсвэрээ зааж өөр тийш нь оруулахыг больчихооч ээ. Сангийн яам бас энэ дээр ажиллаад юу Коп-17 дээр тавигдсан эх үүсвэрийг өөрчлөх боломжгүй юм гэдгийг бас ойлгуулмаар байгаа юм. НҮБ-тай бид нар гэрээ зурчихсан, хэлэлцээр хийчихсэн. НҮБ-ын стандарт гэж тавигддаг. Тэр стандартынхаа дагуу л энэ зардлууд тавигдаж байгаа юм. Түүнээс бид нар өнөөдөр Монголын Засгийн газар байдаг юм уу, Байгаль/минут дуусав*

Ц.Сандаг-Очир: Батбаатар гишүүн үг юм даа. Ажлын хэсгийн 4 номерын микрофон. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ганбат даргын микрофоныг өгье.

Ж.Ганбат: Би энэ дээр нэг зүйлийг тодотгоод хэлчих гээд байгаа нь одоо энэ Засгийн газраас өргөн барьсан энэ 36 сарын тэтгэмжтэй холбоотой энэ мөнгөн дүнгийнхээ хүрээнд төсөв баталсны дараа төсвийн ерөнхийлөн захирагч нар өөрсдөө төсөв дотроо зохицуулаад тэтгэвэрт гарч байгаа хүнийг хохиролгүй байдлаар яваад байх бүрэн бололцоотой гэдэг л юмыг бид хэлээд байгаа байхгүй юу. Одоо бид өмнөх 2017, 2018 гээд төсвийн хүндрэлтэй байдалтай жилүүдэд бид ийм арга хэмжээг аваад, ингээд явж байсан жилүүд байгаа л даа. Бид өөрөөр хэлэх юм бол одоо нөгөө талдаа тэтгэвэрт гарна гэж мөнгөө тусгуулчихаад уучлаарай би сунаад ажиллая гэж хэлээд тэр мөнгө нь хэмнэг дэгдээд явдаг тийм тохиолдлууд практикт зөндөө гардаг шүү дээ. Одоо юу гэдэг юм бид мөнгө нь суучихсан та заавал гар гэж шахахад бас нөгөө талдаа бас эсрэг ийм юм үүсэж байгаа. Тэгэхээр бид төсвийн ерөнхийлөн захирагч нар тэтгэвэрт гарч байгаа хүндээ 36 сарын төсвийнхөө багц дотор батлагдсан хүрээндээ багтаагаад өгөөд явах бүрэн бололцоотой гэдэг ийм л байр суурийг илэрхийлж байгаа юм.

Ц.Сандаг-Очир: Доржзовдын Энхтуяа гишүүн асуултаа асууя.

Д.Энхтуяа: Өглөөний мэнд хүргэе. Би Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Бямбацогт сайдаас нэг асуулт асууя.

Засгийн газар дээр Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах ажлын хэсэг гарсан гэж сонссон. Улсын Их Хурал дээр бас Оюутолгойн гэрээний асуудлаар түр хороо байгуулагдсан байгаа. Энэ түр хороо 2, 3 удаа хуралдсан. Оюутолгойгоос харамсалтай нь бас төлөөлөл ирээгүй байгаа. Өнөөдөр бид нар энэ төсөв хэлэлцэж байхад бол багш нарын цалинг нэмье, тэтгэвэр, тэтгэмжээ нэмье, тэтгэврийн доод хэмжээг 1 сая 500 болгоё. Сая бас энэ Батбаатар сайд хэллээ. Коп-ыг бол яах аргагүй манай улс зохион байгуулна гээд дэлхийд бас амлачихсан байгаа. Гэтэл энэ бүх зардлуудыг чинь бид нар ямар нэг байдлаар эх үүсвэрээс гаргах гээд байна л даа. Тэгээд яг нөгөө тогтвортой явж ирсэн энэ эх үүсвэрүүдээсээ хасаж танана гэхэд бол бас үйл ажиллагаа доголдох хэмжээнд хүрээд ирчихсэн байна.

Тэгэхээр бид нар өнөөдөр энэ Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулахын тулд хэд хэдэн асуудлыг анхаарч үзэх ёстой. Тэгээд яг энэ Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах ажлын хэсэг ямархуу хэмжээнд ажиллаж байгаа вэ. Миний саналаар бол 2009 онд энэ хөрөнгө оруулалтын гэрээг анх байгуулахдаа тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан Ашигт малтмалын тухай хуулиар АМНАТ-ийг тогтворжуулж бас гэрээгээ байгуулсан байдаг. Тэгэхээр 2 талын гэрээ гэдэг бол 2 талаас хоорондоо зөвшилцөөд, ярилцаад, хэлэлцээд, зөвшилцөлд хүрээд, тэгээд гэрээгээ өөрчилж болдог ийм субъект ийм бас итгэлцэл гэж би ингэж харж байгаа юм. Тэгэхээр өнөөдөр Монгол Улсын хэмжээнд хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа энэ Ашигт малтмалын тухай хуулиар бол тусгай АМНАТ-ийг төлөх ёстой байгаа.

Тэгэхээр энэ хуулийн хэрэгжилтийг хангаж, Оюутолгойн гэрээнд яг энэ тусгай АМНАТ-ийг төлөх энэ гэрээ хэлцэлд энэ өөрчлөлтийг оруулж өгөх юм бол өнөөдөр бид нар ингээд орж ирсэн хэдэн төгрөгөө татвар төлөгчдийнхөө мөнгийг тийш нь ч зулгаагаад, ийш нь ч зулгаагаад байх юм байхгүй. Тэгээд манай Монгол Улсын хэмжээнд төсөв нэмэгдэх бүрэн боломж нь өнөөдөр хуулиар нээлттэй байгаад байгаа байхгүй юу. Тэгэхээр хэдүүлээ хэн нэгнийхээ төсвөөс зулгааж хэрүүл хийж суух биш, энэ мөрдөгдөж байгаа хуулийнхаа хэмжээнд Оюутолгойн гэрээнд өөрчлөлт оруулах ийм тал руугаа Улсын Их Хурал нь ч тэр, Засгийн газар нь ч тэр явбал яасан юм бэ. Энэ дээр таны санал бодлыг бас сонсьё.

Тэгээд энэ гэрээний нэмэлт, өөрчлөлт оруулах дээр бол Улсын Их Хурлын тогтоолын төсөл боловсруулах шаардлагатай бол гишүүний хувиар би тогтоолын төсөл боловсруулаад Засгийн газартай хамтарч ажиллах бүрэн боломжтой гэдгээ бас хэлье.

Ц.Сандаг-Очир: Энхтуяа гишүүний асуултад Бямбацогт сайд хариулъя.

С.Бямбацогт: Энхтуяа гишүүн бас чухал асуудал хөндөж байна. Тэгээд Монголчууд бид 1 л эх оронтой, бүгд нэгдмэл эрх ашигтай, үнэт зүйлтэй ийм л хүмүүс. Тийм болохоор бас Оюутолгойн гэрээг сайжруулах тал дээр Улсын Их Хурал, Засгийн газар бас 1 тал болж, 1 цонхоор харж ажиллаж байгаа. Засгийн газраас 3 сайдаар ахлуулсан 3 ажлын хэсэг гарсан байгаа. Энэ Оюутолгойн гэрээний зээлийн хүү менежментийн төлбөртэй холбоотой асуудлыг бууруулахтай холбоотой асуудлыг Сангийн сайд Жавхлан ахалж байгаа. Лондоны Арбитрын шүүх дээр бас гарсан маргаантай холбоотой асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Мөнхбаатар ахалж байгаа. Онтре компани буюу Оюутолгойн ордын лицензтэй холбоотой асуудлыг Дамдинням сайд ахалсан ийм 3 ажлын хэсэг гарч ажиллаж байна. Ерөнхий сайдын захирамжаар гарсан. Ажил бол нэлээн эрчимтэй явж байгаа. Ялангуяа 8 сард Ерөнхий сайдын захирамж гарсан. Үүнээс хойш бол Засгийн газрын гишүүд, холбогдох ажлын хэсгийн ахлагч нар ойр ойрхон хуралдаад ажлаа нэлээн эрчимжүүлж байгаа. Бид ойрын үед Оюутолгой компанитай, Рио Тинто компанитай хэлэлцээр хийх ажлын төлөвлөгөө баталж, ажиллах гэж байгаа. Рио Тинто компаниас үндсэндээ хэлэлцээрт оролцъё, сууя. 2 талаас асуудлаа ярьж гэдэг дээр албан ёсоор бас бидэнд бас бичгээр хандсан байгаа. Тийм болохоор тодорхой үр дүн гарах байх гэж найдаж байгаа.

Анх 2009 онд Оюутолгой компани Рио Тинто компанитай тухайн үед хөрөнгө оруулалтын гэрээг 30 жилийн хугацаатай байгуулсан юм байна лээ. Энэ 30 жилийн хугацаанаас 16 жил нь өнгөрчихсөн байгаа. Тухайн үед Монгол Улсын эдийн засаг, төсөв нэлээн хүндрэлтэй. Гаднын хөрөнгө оруулалт Монгол Улсад орж ирэх юм бол Монгол Улсын эдийн засагт нэлээн тийм томоохон тэлэлт бий болох ийм нөхцөл байдал үүсэхээр байсан учраас тухайн үед гэрээг байгуулах тал дээр тухайн үеийн Засгийн газар бас идэвхтэй ажилласан. Энэ ажиллах явцдаа бас туршлага дутаад, алдсан талууд бас байгаа юм байна лээ. Анх 2009 онд ярьж байхад нийт Оюутолгой төслийн үр өгөөж нь 57 хувь нь Монголын талд ноогдоно, 43 хувь нь гадаадын хөрөнгө оруулагч компанид ноогдоно гэж ярьж байсан. Тийм нөхцөлтэй гэрээ хийгдсэн бол өнөөдөр бодит байдал дээр 25 хувь нь Монголын талд, 75 хувь нь Рио Тинто компанид ноогдож байгаа. Зээлийн хүү өндөр байгаа. Менежментийн төлбөрийг үр ашгаас үр дүнгээс авдаг биш 6 хувийн төлбөрийг зардлаас авдаг байгаа. Энэ бүгдийг нэн яаралтай өөрчлөх ёстой. Энэ өөрчлөгдөх юм бол энэ хэмжээгээр Монголын талд ноогдох үр өгөөж нэмэгдэнэ. Үр өгөөж. Энэ тал дээр Улсын Их Хурал, Засгийн газар бол 1 тал болоод, нэлээд эрчимтэй ажиллаж байна. Үр дүн гарах байх. 2025 он дуусчихвал яах вэ гэж санаа зовохгүйгээр ер нь хэлцэл хийж байгаа бол Монгол Улсад Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын хууль үйлчлэх ёстой. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа бол энэ хүрээндээ бид нар бас ойлголцоод явах бололцоотой гэж харж байгаа. Ганцхан хөрөнгө оруулалтын гэрээг тогтворжуулаад, 30 жилийн хугацаанд ямар нэгэн өөрчлөлт хийхгүй гээд хатуу заачихсан юм байна лээ. Хөрөнгө оруулалтын гэрээ. Тийм болохоор хөрөнгө оруулалтын гэрээ дээр заачихсан таны саяын хэлсэн татваруудыг тогтворжуулчихсан. Хөрөнгө оруулалтын гэрээнээс гадна тэр хувь нийлүүлэгчдийн гэрээн дээр байж байгаа тэр менежментийн төлбөр, мөн зээлийн хүүгийн зардлыг бууруулах тал дээр бид илүү бас онцгой анхаарч ажиллаж байгаа. 7 жилд 1 удаа өөрчлөлт хийх ёстой энэ хүрээнд. Үүнээс гадна бол төсөв дагуулаад

бид Тавантолгойн бүлэг ордоос үлдсэн 1 орд байгаад байгаа. Бортээгийн орд гэж. Бусад нь үндсэндээ бол эдийн засгийн эргэлтэд орчихсон ингээд явж байгаа. Энэ Бортээгийн ордыг эдийн засгийн эргэлтэд оруулж, улсын төсөвтөө бас орлого оруулъя. Үүгээрээ бас цалин, тэтгэвэр, ахмадын тэтгэвэр, бусад шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх эх үүсвэрийг бас эндээс гаргаж ирэх бололцоо боломж бүрдэх болов уу гэдэг үүднээс өргөн барьсан байгаа. Энийг бас манай Улсын Их Хурлын гишүүд бас анхааралдаа авч, энийг хэрхэн яаж илүү үр ашигтай, илүү үр үр өгөөжтэй Монголын ард түмэнд, Монголын төрд үр өгөөжтэй байх тал дээр бас анхаараасай гэж хүсэж байна.

Ц.Сандаг-Очир: Тодруулах уу. Болсон уу. Энхтуяа гишүүн тодруулга 1 минут.

Д.Энхтуяа: Би бас дахиад хэлье. Ер нь энэ гэрээ гэдэг бол бас огт өөрчилж болдоггүй зүйл бол биш л дээ. Тэгэхээр өнөөдөр бол Монгол Улсын хэмжээнд яг хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа Ашигт малтмалын тухай хуулиар бол өсөн нэмэгдэх АМНАТ төлөх ёстой. Энэ АМНАТ-ийг Эрдэнэт үйлдвэр бол маш сайн төлж байгаа. Бусад аж ахуйн нэгжүүд ч төлж байгаа. Гэтэл Оюутолгой бол бас манай дотоодын аж ахуйн нэгж хэр нь яагаад энийг бид нар засаж сайжруулж болдоггүй юм бэ гэдгийг л бас би дахин дахин хэлмээр байна. Тэгээд ер нь бол эзэн нь юмаа мэдэж, эрэг нь усаа хашдаг гэдэг бас нэг ийм сайхан үг байдаг. Бид нар дараагийн ордыг ашиглаад зээлээ төлчихье, дараагийн ордыг ашиглаад тэтгэврээ нэмчихье гэж ярьж байхын оронд өнөөдөр байж байгаа энэ үйл ажиллагаа нь жигдэрчихсэн энэ хөрөнгө оруулалтынхаа гэрээг, энэ уурхайгаа бид нар ашиглаад, өнөөдөр Монгол Улсынхаа төсвийг 3, 4, 5 дахин нэмэх ийм боломж өнөөдөр бид нарт байгаад байгаа юм. Энийг бас дахин дахин хэлье дээ.

Ц.Сандаг-Очир: Үг хэлчихлээ дээ. Би гишүүнийхээ хувьд 1 асуулт асууя.

Тэгээд 1, 2 дугаар хэлэлцүүлэг яваад дууссан. Эндээс харахад манай энэ жил Эдийн засаг, хөгжлийн яам, Сангийн яамныхны үгийг сонсохоор зардлыг нэмэгдүүлэхгүй. 24 хувьдаа барина. Хөгжлийн ерөнхий төлөвлөгөөндөө дотоодын нийт бүтээгдэхүүний 24-өөс ихгүй байна зардал гэж ингэж яриад ам хаагаад байгаа юм. Тэгээд зардал нэмэгдүүлэх бололцоогүй болчихсон байна гээд. Тэгээд та бүхэн бол дуртай үедээ ер нь бол Төсвийн тухай хуулийг дагалдуулаад л энэ байтугай зүйлийг л оруулж ирдэг шүү дээ. Тэр битгий хэл Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, тэгээд төсвийн хүрээ тусгай шаардлагынхаа үзүүлэлтүүдийг ингээд л тодотголоор хүртэл өөрчлөх үедээ бол өөрчлөөд л оруулаад ирдэг юм шүү дээ. Тэгээд үнэхээр тэрэнд баригдаад байгаа юм бол энийгээ өөрчлөөд тэгээд энэ урсгал зардлыг тэр 24 хувьд баригдаад байгааг нэмэгдүүлэх бололцоо боломжийг гаргаад, тэгээд энэ гишүүдийн яриад байгаа энэ цалин тэтгэврээ урсгал задлаад тэрэндээ нэмэгдүүлээд явах бололцоо, боломж байхгүй юм уу. Тэгээд л жигтэйхэн хууль барьдаг юм шиг одоо л энэ удаагийн төсөв дээр л хууль барьж байгаа юм шиг харагдаад. Хэрвээ та нар хуулиа зөрчихдөө бол өөрсдөө тааруулаад л үзүүлэлтүүдээ дур дураараа л өөрчлөөд л явдаг шүү дээ. Төсвийн тухай хуулийг дагалдуулаад л Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийг өөрчлөлт оруулаад л ирдэг шүү дээ. Энэ жил гэв гэнэтхэн яагаад болохоо больчихов. Энэ хөгжлийн төлөвлөгөөнд дурдсан 24 хувийн баригдах энэ зардлыг яагаад нэмэгдүүлэх бололцоо, энэ хуульд нь дагалдуулаад өөрчилж болохгүй юм уу. Тэгвэл орон зай үүсчих бололцоо боломж байгаа юм биш үү. Энэ дээр та бүхэн юу гэж үзэж байгаа юм. Хариулж өгөөч. Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Ж.Ганбат: Бид Засгийн газраас төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ тэтгэврийг 6 хувиар, цалинг нэмэгдүүлэхгүй байхаар тооцож төсвийн төслийг бол өргөн мэдүүлсэн. Тэгээд төсөв бол боловсруулахдаа Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль дээр заасан тусгай шаардлагуудын хүрээнд л бид боловсруулж өргөн барьдаг л даа. Тэгээд сая Төсвийн байнгын хороо дээр Төсвийн байнгын хорооны даргаас өгсөн чиглэлийн дагуу багш нар, эмч нарын цалингийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх вэ гэдэг дээр Сангийн яаманд болон Засгийн газарт холбогдох тооцоолол хийхийг үүрэг өгсөн байгаа. Бид яах вэ, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн зардлынхаа дүн дотор багтаагаад, эх үүсвэрийг гаргах ямар боломж байна гэдэг тооцооллыг Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам бол холбогдох тооцооллын юмнуудыг нь бол хийж байна. Тэгээд энэ тооцооллоо бид дуусахаар нь Төсвийн байнгын хорооны ажлын хэсэгт Төсвийн байнгын хороонд танилцуулаад, ямархуу байдлаар явах вэ гэдгийг бол тооцоод явж байгаа. Зүгээр яах вэ, сая энэ 2025 оны төсвийн тодотгол дээр бид орлогыг 3 их наядаар, зарлагыг 2 их наядаар бууруулаад нэлээн таналтуудыг хийчихсэн байгаа. Тэгээд одоо дахиад энэ эх үүсвэрийг гаргахтай холбоотой бид урсгал зардал дээр дахиад хууль засах ямар боломж байна гэдэг иймэрхүү байдлаар бол тооцооллуудыг хийж ажиллаж байгаа тэгээд хараахан арай дуусаагүй байгаа.

Ц.Сандаг-Очир: Тодруулъя. Нөгөө халдавч хар ямаандаа гэдэг шиг тэгээд муу л бол нөгөө хэдэн төрийн алба руугаа, төрийн байгууллагууд руугаа л дайрч байгаа юм л даа. Энэ байгууллагууд чинь бүсээ чангалаад чангалаад гэдэг юм уу, төсвөө тодотголоор хасуулаад хасуулаад маш хүнд нөхцөлд ажиллаж байгаа шүү. Одоо ахиад энэ цалин тэтгэврийг нэмэгдүүлэх тал дээр Засгийн газар шийдлээ гээд сайд нарын багцыг урсгал зардлыг ахиад ингээд 10 хувиар хасна гэдэг бол эргээд ачаалал нь төрийн байгууллагууд дээр ирж байгаа юм. Тэгээд төрийн байгууллагуудын хэвийн үйл ажиллагаа явагдах бололцоо боломж ер нь та бүхэн юу гэж харж байна. Энэ алдагдаж байгаа юм биш үү. Хэвийн үйл ажиллагаа явуулах төрийн байгууллагуудыг зөвхөн цалин авдаг байдлаар харж болохгүй шүү дээ. Олон зардлууд гарах ёстой шүү дээ. Төрийн үйл ажиллагаа явуулахад энэ зардлууд нь ингээд бүгд хасагдаад 10 хувиар тэгшитгээд хасчихаар байгууллагууд чинь ер нь хэвийн үйл ажиллагаагаа явуулах хэмжээнд байна уу, үгүй юу. Энийг та бүхэн юу гэж харж байгаа юм. Засгийн газар дээр Ганбат дарга хариулж өгөөч.

Ж.Ганбат: Сая энэ онд тодотголоор төсвийг 2 их наядаар зардлыг бол нэлээн танасан. Ер нь бол яг орон нутгаас эхлээд бүх шатын төсвийн байгууллагууд дээр хэмнэлтийн горимоор бол ажиллаж байгаа. Тэгээд дахиад бид нэгэнт Улсын Их Хурлын төсөв хэлэлцэн цалин тэтгэвэр нэмэгдүүлэх, багш нарын цалин, эмч нарын цалинтай холбоотой бид эх үүсвэр гарга гэдэг ийм чиглэл бол Төсвийн байнгын хорооноос өгчихсөн учраас бид энэ дээр дахиад л урсгал зардал дотор нь дахиад л таналт хийхээс өөр аргагүй. Тэгж л бид нар эх үүсвэр гаргана. Тэгээд энэ хүрээндээ багтаагаад л төсвийн байгууллагуудыг бүх шатын байгууллагуудыг бид хэмнэлтийн зарчим бариад ажлаа ч гэдэг ийм өөр арга байгаа. Бид сая төсвийн тодотгол дээр төрийн албан хаагчдын тоог 9 хувийн цомхотголыг хийсэн. Тэгээд дахиад урсгал зардал дээр бид дахиад хэмнэлтийн байдлаар ажиллаач ээ гээд, тэгээд энэ хүрээндээ бид цаашаа явахаас өөр аргагүй ийм л нөхцөл байдалтай байгаа.

Ц.Сандаг-Очир: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл

мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлаж үг хэлэх гишүүд байна уу. Нэрсээ өгөөрэй. Гишүүд сая асуултаа асуугаад, хариултаа аваад дуусчихлаа. Зарчмын зөрүүтэй санал дээрээ санал гаргасан гишүүд саналаа тайлбарлаж гэж үг хэлэх нэрсийг авч байна. Ариунзаяа гишүүнээр тасаллаа. Ирцэд орсон Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: 1 дүгээрт бид төрийн эрх барих дээд байгууллага өөрсдөө хуулиа бас чандлан сахих хэрэгтэй гэдэг үүднээс Төрийн албаны тухай хуулийг зөрчиж байгаа, Төсвийн тухай хуулийг зөрчиж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарч байгаа төрийн албан хаагчдын төрөөс олгох ёстой тэтгэмжийг эх үүсвэрийн 50 хувь л суулгасан нь буруу юм. Ийм учраас үүнийг бүрэн гүйцэд тавих үүргийг бид хүлээх ёстой.

Миний зарчмын зөрүүтэй санал дээр бол Коп-ын энэ барилга байшинтай холбоотой санал бол 35 тэрбум төгрөгийг оруулж байгаа. Энэ нийт санхүүжилтийн дүн, нийт төсөвт өртгийг нь бууруулаагүй. 150 тэрбум хэвээрээ байгаа. Гагцхүү энэ 2026 онд тавигдсан байгаа дүнгийн 35 тэрбумыг нь л ёстой жинхэнэ нөгөө Ганбат даргын хэлдгээр 1 жил хойшлуулах ийм санал байгаа буюу 2026 онд тавигдаж байгаа энэ санхүүжилтийн 35 тэрбум төгрөгийг нь төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэр тогтоолгоход олгох тэтгэмжид шилжүүлэх ийм санал байгаад байгаа юм.

Тэгэхээр Төсвийн тухай хуулиараа ч барилга байшингийн төсөвт энэ өртгийг 3 хувааж өгөх зарчим хүртэл үйлчилж байгаа шүү дээ. Тэгээд энэ төсвийн хуулиа ч ердөөсөө барихгүй, зарчмаа ч барихгүй ийм нөхцөлийг Сангийн яам өөрөө үүсгээд байгаад бас жоохон харамсаж байгаа. Тэгэхээр энэ бол болохгүй буруу, эсвэл Коп-ыг бүр огт зохион байгуулж чадахгүй болж байгаа асуудал огт биш юм гэдгийг бас Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүддээ хэлмээр байна. Энэ ер нь бол Сангийн яам байшин барилгын санхүүжилтийг бас олон жил дараалж хувааж өгдөг ийм явдал байгаад байдаг. Тэгэхээр энэ дээр Батбаатар сайд маань айгаад, Коп маань ердөөсөө зохион байгуулагдахаа болих нь гэж ердөөсөө айж, эмээж болохгүй. Би нийт өртгийг нь бууруулаагүй. Зөвхөн санхүүжих дүнг нь Төсвийн тухай хуульдаа бас нийцүүлж шилжүүлэх ийм арга замыг хайж, аргагүйн эрхэнд л ийм саналыг оруулж байгаа. Миний зарчмын зөрүүтэй саналыг дэмжсэнээр бид хуулийн зөрчлийг арилгах юм гэдгийг нэг талдаа сануулж, нөгөө талдаа олон тэтгэвэртээ гарахыг хүлээж байгаа төрийн албан хаагчид бас сэтгэлээ чилээхгүй тэтгэвэртээ гаргах боломжийг нь бид бас хангаж өгөх юм гэдгийг сануулъя. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Та бүгдийн энэ өдрийн амгаланг эрье. Тэгэхээр энэ төсвийг 10 хувиар танах асуудал байна шүү дээ. 2009 оны гашуун түүхийг давтах нь.

2009 онд бас эдийн засгийн хямрал яваад бид нар яг ингээд төсөв хэлэлцэж байхдаа манай 1 популист хэдэн улс төрчид нийт төсвийг 10 хувиар таная гэдэг ийм санал гаргасан юм. Одоо энэ Ганбат эд нар санаж байгаа байх. Тэгээд нийт төсвийг 10 хувиар танасан. Хамгийн том төсөвтэй салбарууд бол боловсрол, эрүүл мэнд. Энэ салбараас 10 хувь танана гэдэг бол үнэхээр ноцтой үр дагаврыг авчирдаг. Бид нар тухайн үед ингэж танаснаар 12 хүүхдийн амь насанд хүрсэн. 12 хүүхэд хүйн халдвараар нас барсан. Яагаад нас барсан гэхээр бид нар аваачаад ийм том төсөвтэй нөгөө эрүүл мэндийн салбарын төсвийг аваад хаячихаар тэд нар ариутгалын бодисоо авч чадаагүй. Ариутгалын бодисоо авч чадаагүйгээс болоод

яасан, хүүхдийн амь нас эндсэн. Тэгээд бид нар Ламбаа сайдыг огцруулах асуудлыг оруулсан тухайн үед. Харамсалтай нь тэр үед Ламбаа сайд Солонгост эмчилгээнд явчихсан байсан учраас хэлэлцэгдэхгүй амь аврагдаж үлдсэн юм байгаа юм. Тэр өнөөдөр хүүхдийн биш юм гэхэд хэн нэг өвчтөний амь насыг эрсдэлд оруулах ийм алхмыг өнөөдөр бид нар Их Хурал хийх гэж байна шүү дээ. Ямар нэгэн юм дутагдаж магадгүй, ямар нэг бодис нь дутагдаж магадгүй. Худалдаж авах гэж байгаа юмнууд нь нийлүүлэгдэхгүй болж болзошгүй эрүүл мэндийн салбарын хувьд. Хүүхдүүдэд ч гэлээ гэсэн. Тэгэхээр би зүгээр гишүүддээ анхааруулж хэлэхэд ийм түүх байсан шүү. Ахиад боловсрол, эрүүл мэндийн салбарт ийм юм болуузай. Ер нь төрийн хариуцлага гэж юмыг ухамсарлахаа, ойлгохоо больсон байна. Энэ гишүүн хүн гэдэг чинь төр барилцаж байгаа хүн. Төр барьж байгаа хүн. Тэрнээс биш ингээд хөнгөн хийсвэр хандаад, орж ирснийг нь бүгдийг нь ингээд гар өргөөд сууж байдаг байж болохгүй. Ер нь эрүүл мэнд, боловсролын салбарын төсвөөс ийм өндөр хувиар танана гэдэг бол маш том эрсдэлийг дагуулна. Хамгийн том төсөвтэй байхгүй юу энэ 2 байгууллага. Тэгээд сайн бодоцгоогоорой. Ажлын хэсэг дээрээ сайн ярьцгаагаарай. Ер нь төрийн алба суларч, ялангуяа төрийн эрх байгууллагын хувьд бол иймэрхүү зүйл дээр хайнга ханддаг ийм юм ажиглагдаж байна.

Сая мөнгөний бодлогыг хэлэлцэж байгааг харахад тийм байна шүү дээ. Мөнгөний бодлого, төсвийн бодлого 2 бол уялдаатай байх ёстой. Ялангуяа эдийн засаг хямарч байгаа энэ үед бол бид мөнгөний бодлогыг маш сайн ярих ёстой байхгүй юу. Тэр валютын ханшийн өөрчлөлт ороод байгаа хэн хариуцах ёстой юм. Энэ мөнгөний бодлогын асуудлаар хэн хариуцлага хүлээх байсан. Мөнгөний бодлогоо бид нар эдийн засаг хямарч байгаа, нүүрсний орлого буурч байгаа энэ үед яаж авч явах юм гэдэг бодлогыг гаргахгүй, шууд кнопдоод явуулчихаж байна шүү дээ. Одоо төсвийг бас тийм нөхцөл байдал үүсчихлээ шүү дээ. Тэгээд л орж ирснээр дараад байгаа. Засгийн газар 2, 3 сарыг харж төлөвлөж чадахгүй байна шүү дээ. Оруулж ирсэн төсвийнхөө хойноос ийм боломж байна гэж байгаа байхгүй юу. 8, 9 сарыг харахаар ийм боломж байна гэж юу гэсэн үг юм. Бүтэн 1 жил, 2 жилийг харж төлөвлөж чаддаг байх хэрэгтэй шүү дээ. Тэгж байж төсвөө оруулж ирэх ёстой шүү дээ. Гэтэл 9 сарыг харсан чинь боломж гарчихлаа гээд ингэж байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм л болсон байна манай төр, засаг. Алсыг харж бодож төлөвлөж чадахгүй болсон байна шүү дээ. Одоо магадгүй 1 сарын дараа худлаа юм байна. 10 сарын гүйцэтгэлийг харсан чинь болохгүй юм байна гээд сууж байх уу. Ийм хариуцлагагүй зүйл ярьдаг байж болохгүй шүү дээ засаг гэдэг чинь.

Ц.Сандаг-Очир: Би бас үгээ хэлье. Энэ гишүүдийн ярьж байгаа үнэн шүү. Засгийн газар 1 гараараа болохоор төрийн албан хаагчид гэдэг юм уу, боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдын цалинг нэмнэ гэж яриад, нөгөө гараараа болохоор нөгөө талдаа 10 хувиар нь хасна гэж байна шүү дээ зардлыг нь. Энийг чинь юу гэж ойлгох юм. Нэмэх гээд байгаа юм уу, нэмэхгүй гээд байгаа юм уу. Ингээд багш, эмч нарыг хуурч өнгөрөөх гээд байгаа юм уу. Одоо энэ эмнэлэг, сургууль, цэцэрлэгүүд чинь төсөв нь маш хүнд болчихсон юм байна шүү дээ. Зөвхөн энэ төрийн байгууллагууд цалингаас өөр гүйлгээ хийхгүй, бүх гүйлгээнүүдийг нь хаачихсан, татчихсан. Энэ эмнэлгүүд чинь ерөөсөө эм тарианы мөнгө байхгүй, өвчтөнүүдийг өөрсдөө эм тарианыхаа мөнгийг олж ир, эм тариагаа өөрсдөө олж ир гэж ингэж явуулж байна шүү дээ. Тэгээд 10 сар, 11 сар, 12 сарынх нь цалингийн хуваариуд нь батлагдаж ирсэн чинь дандаа 20, 30 хувиар зардал нь танагдаж ирчихсэн. Өмнөх онтой харьцуулахад. Үгүй ээ, тэгээд энэ байдлаар харахаар оны эцэс рүү эмнэлгүүд эмч нарынхаа цалинг тавьж чадахгүй байдал руу орно. Сургууль багш нарынхаа цалинг тавьж чад чадахгүй байдал руу орохоор, цэцэрлэг мөн адилхан. Ийм хүнд байдал руу орчихсон байна шүү дээ. Гэтэл өнөөдөр худлаа

цалинг нь нэмнэ гэдэг байдлаар асуудалд хандаад, овоо нэмэх гэж байгаа юм уу гэхээр одоо урсгал зардлаа 10 хувь хас гээд зөрүүлээд бойкотод оруулаад, энийг чинь ямар улс төрийн гэдэг юм уу, ямар эдийн засгийн шийдвэр гэх юм бэ. Энэ зөв шийдэл мөн үү. Та нар маань энийг амьдрал дээр мэдэж байна уу, үгүй юу. Яг энэ эмнэлгүүд ямар байгааг, сургууль, цэцэрлэгүүд ямар байгааг төсөв нь ямар байгааг. Орон нутгийн төрийн байгууллагууд ямар байгааг ерөөсөө цалингаас өөр зардал гүйлгээ хийхгүй гээд татчихаад байгаа юм байна шүү дээ. Энийгээ энэ Сангийн яамныхан мэдэж байгаа юу.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71.6-д заасны дагуу төсвийн төслүүдтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүдийн санал тус бүрээр санал хураалт явуулна. Санал хураалтдаа бэлдээрэй.

Бадамсүрэн гишүүн хаачив. Санал хураалт ороогүй байна. Бат-Эрдэнэ гишүүн ороогүй байна. Бямбацогт гишүүн ороогүй байна. Ганбаатар гишүүн ороогүй байна. Даваасүрэн гишүүн ороогүй байна. Мөнхбаатар гишүүн ороогүй байна. Номин гишүүн ороогүй байна. 13 гишүүн орсон байна. 7 гишүүн ороогүй байна. Санал хураалтад эсрэг санал тооцож болохгүй гэсэн шүү дээ. Өчигдөр Цэц болохгүй гэсэн.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд нэр бүхий гишүүдээс зарчмын зөрүүтэй санал гаргасан. Ариунзаяа гишүүний саналыг хураалгая. Зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүдийн саналыг тэгээд гишүүд өөрсдөө итгэл үнэмшлээрээ дэмжихийг нь дэмжээд, дэмжихгүйг нь унагаад л явна шүү дээ. Өөрсдөө л мэднэ. Та бүхний л асуудал шүү дээ. Зарчмын зөрүүтэй санал гаргах нь гишүүдийн эрх. Ямар санал гаргах нь гагцхүү гишүүд гаргаж байгаа санал нь нэмэгдүүлэх гэж байгаа санал байвал хаанаас нэмэгдүүлэх гэж байгаа эх үүсвэрээ тодорхой хэлэх хэрэгтэй. Нэг газраас хасаж, нөгөө газар дээр нэмнэ. Ийм л асуудал байгаа шүү дээ.

Төрийн байгуулалтын байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд Улсын Их Хурлын гишүүн байнгын хорооны гишүүн санал хураалт эхлээгүй байгаа учраас та зарчмын зөрүүтэй саналынхаа агуулгыг өөрчлөөд ир.

1.Идэрбат гишүүнээс дараах саналыг гаргасан байна.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой, “Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/ хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 404,3 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий Баян-Адарга сум/ хэрэгжих хугацаа 2026-2026 онд төсөвт өртөг болон санхүүжих дүн 404,3 сая төгрөг” гэсэн төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Хэнтийнхээ батлагдсан хөрөнгө оруулалтын зардал дотроо л замынхаа ажлаас багасгаад, иргэдэд үйлчлэх цэг болгоё л гэж байгаа юм байна. Тэрнээс төсөв нэмэгдэхгүй юм байна. Идэрбат гишүүн өөрөө санал гаргаад байхгүй байна. Замынхаа төсвийг л барилга болгоё гэж байгаа юм байна. Сумуудын л Тамгын газрын барилга л болгож байгаа юм шиг байна. Саналаа хураагаад л явчихъя гишүүд минь.

Идэрбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 20 гишүүнээс 6 гишүүн дэмжиж, 30 хувиар Идэрбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй.

2 дахь санал зарчмын зөрүүтэй санал мөн Идэрбат гишүүний гаргасан санал байна.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804408 төслийн кодтой, Бор-Өндөр-Хэрлэн чиглэлийн хатуу хучилттай авто зам, 179,7км /Хэнтий Баянмөнх, Дархан, Бор-Өндөр сум/ хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 186,000.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 40,000.0 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 434,1 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий Баян-Овоо сум/ хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүн 434,1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Агуулга нь яг мөн адилхан юм байна. Замаасаа Баян-Овоо сумын иргэдэд үйлчлэх төвийн барилгын ажлыг гэж байгаа юм байна. Санал хураалт явуулъя. Идэрбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 21 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 38,1 хувиар Идэрбат гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй.

3 дахь мөн адилхан Идэрбат гишүүний гаргасан.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2402804410 төслийн кодтой, /Жаргалтхаан-Өмнөдэлгэр чиглэлийн авто замаас Биндэр чиглэлийн хатуу хучилттай авто зам, 152,5км /Хэнтий, Өмнөдэлгэр, Баян-Адарга, Биндэр, Хэрлэн сум/ хэрэгжих хугацаа 2024-2027 он, төсөвт өртөг 202,137.9 сая төгрөг 2026 онд санхүүжих дүн 23,950.1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 951,8 сая төгрөгөөр бууруулж, энэ эх үүсвэрээр “Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилгын нэмэлт санхүүжилт /Хэнтий Бэрх тосгон/ хэрэгжих хугацаа 2026-2026 он, төсөвт өртөг болон санхүүжих дүнд 651,8 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр нэмж тусгах.

Гишүүд ээ, анхааралтай байгаарай. Идэрбат гишүүний гаргасан 3 дахь зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 21 гишүүнээс 5 гишүүн дэмжиж, 23,8 хувиар Идэрбат гишүүний гаргасан 3 дахь зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй.

4.Баярбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг уншиж танилцуулъя.

Боловсрол, Эрүүл мэнд, гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбараас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын урсгал зардлыг 0,37 хувиар буюу 290,204.3 сая төгрөгөөр бууруулж, төслийн 2 дугаар хавсралтын УТ2603800007 төслийн кодтой, Сонгуулийн ерөнхий хорооны тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ хэрэгжих хугацаа 2026-2028 он, төсөвт өртөг 41,720.4 сая төгрөг, санхүүжих дүн 12,516.1 сая төгрөг” гэсэн төсөл арга хэмжээний санхүүжих дүнг мөн дүнгээр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар. Баярбаатар гишүүн саналаа.

Б.Баярбаатар: Гишүүддээ өдрийн мэнд хүргэе. Энэ гол асуудал болчхоод байгаа юм. Манай сонгуулийн санал тоолох машин маань 2012 оноос хойш ингээд 4 удаагийн сонгуулийн цикл ажиллаад актлахад бэлэн болчихсон. Цаашлаад бол сонгууль энэ санал тоолох машинаар бол явах боломж байхгүй.1.

2-т нийтдээ 3500 санал тоолох машин байдаг. 500 машиныг нь бол өнгөрсөн оны төсвийн тодотголоор сольсон. Канад улсын санал тоолох машин байгаа. Одоо 3000 санал тоолох машиныг бол солих зайлшгүй шаардлага бол үүсчихсэн. Дээр нь энэ санал тоолох машины төсвийг бид нар төсвийн ерөнхийлөн захирагчдаас 1 хувь ч биш бүр 0,37 хувийг татаж байгаа. Төсвийн ерөнхийлөн захирагчид бол энэ дээр ямар нэгэн гомдол, санал байхгүй гэдгээ тодорхой түвшинд бас саналыг нь аваад илэрхийлчихсэн. Энэ машиныг маань одоо энэ 3000 машиныг хийхэд дор хаяж 1 жилийн хугацаа, үйлдвэрлэх хугацаа нь. Тэгэхээр бид 2027 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн өмнө энэ санал тоолох машинаа тоолохгүй бол иргэдэд нөгөө хардалт сэрдэлтийн асуудал маань өөрөө буруу зөрүү ойлголт төрчих гээд байгаа учраас энэ технологио бас солих зайлшгүй шаардлага үүсчихсэн. Тэгэхээр энэ саналыг гаргаж оруулж байгаа юм. Гишүүд маань бас дэмжиж өгнө үү гэж хүсэж байна. Сонгуулийн ерөнхий хороо энэ дээр нэмээд тайлбарлачихъя. Энэ 2026-2028 он гэдгийг яг ямар агуулгаар тавьсан юм бол. Энэ дээр энэ чинь бараг 2027 ондоо дуусчихмаар юм биш үү. Бат-Эрдэнэ дарга энэ дээр та нэмээд тайлбарлахгүй бол энэ дээр бас зарим нэг ойлгомжгүй зүйл ажиглагдаад байна.

Ц.Сандаг-Очир: Сонгуулийн ерөнхий хорооны Тамгын газрын дарга. Энэ чинь машиныг нь солих юм уу, программыг нь солих юм уу. Энийгээ олигтойхон тайлбар тайлбарлаад өг дөө. Ажлын хэсгийн 4 номерын микрофон.

Д.Бат-Эрдэнэ: Автоматжуулсан системийн тухайд бол ямар ч ажиллагааг солих юм байхгүй. Зөвхөн төхөөрөмжийг солих тухай байгаа. Акталчихсан байгаа. Дээрээс нь энэ төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зүгээс үйлдвэрлэх, нийлүүлэх хугацааг бол 11 сарын хугацаа гэж өгч байгаа учраас бид ирэх оны төсөвт тусгаж багтааж авахгүй л бол 2027 оны Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулиар хүндрэлтэй болон эрсдэлтэй ийм нөхцөл байдал үүсэх болчхоод байгаа юм. Тэгээд гишүүд энийг ойлгож өгөөч. Өмнө нь бол энэ ашиглалтын хугацааг 2018 болон 2023 онд 2 удаа сунгачхаад байгаа юм. Тэгээд одоо бол хамгийн сүүлд сунгахдаа 2024 оныг дуустал ашиглаад цаашаа бол ашиглах боломжгүй гэдэг дүгнэлт гарчихсан учраас бид нар ирэх жилийн төсөв дээр тусгаж авахгүй л бол сонгууль маань эрсдэлтэй ийм нөхцөл байдалд орох гээд байгаа ийм нөхцөл байдал байгаа.

Хэрэгжих хугацааны тухайд бид нар зөвхөн 2026 оны ирэх оны төсөвт тусгаж авахгүй бол үе шаттайгаар хувааж авах юм бол боломжгүй болно. Үгүй ээ уг нь тэгж орж ирээгүй. 2028 биш.

Ц.Сандаг-Очир: Ийм учиртай юм байна гишүүд ээ. Төхөөрөмжийн хугацаа дууссан гэж байгаа юм байна. Төхөөрөмжийнх нь хугацаа. Цаад нийлүүлэгч компаниас нь 1 удаа сунгасан гэж байгаа. Тийм ээ. 2 удаа сунгачхаад, одоо 3 дахь удаагаа сунгаж болдоггүй юм уу. 2 удаа сунгаж болж байгаа юм чинь 3 дахь удаагаа сунгаж болдоггүй юм уу. 15 жил болчхоод байгаа юм уу. Нэмж авах гээд байгаа юм уу. Одоо байгаа юмнуудаа бүр солино тийм ээ. Нийт машиныхаа 3-ны 1-ийг нь сольчихоод байгаа. 3-ны 2 нь солигдоогүй байгаа гэж ойлгож байгаа тийм үү. Хэрвээ энэ машиныг сольж чадахгүй бол 2027 оны Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулах бололцоогүй болно л гэж үзэж ойлгож болох уу. Энэ дээр

Тамгын дарга хариул даа. Ерөнхийлөгчийн сонгуулийг явуулах бололцоо боломж нь энэ машиныг солих, солихгүйгээс хамаарах юм уу. Энэ дээр хариулаадах. Эхлээд Тамгын дарга. Ажлын хэсгийн 4 номер.

Д.Бат-Эрдэнэ: 2026 ондоо багтааж энэ төхөөрөмжийг шинэчлэх, нөхөн бүрдүүлэх энэ ажлыг хийхгүй бол 2027 оны Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулийг зохион байгуулахад маш хүндрэлтэй ийм нөхцөл байдалтай шууд үүснэ. Санал тоолох төхөөрөмжийг бүр ашиглах боломжгүй болно л гэсэн үг.

Ц.Сандаг-Очир: Баярбаатар гишүүний микрофон.

Б.Баярбаатар: Гол асуудал энэ сонгууль шударга явагдах ёстой. Иргэд энэ санал тоолох машинд итгэл өндөр байх ёстой. Одоо бид нар энэ 15 жил ашиглачихсан машинаар бол магадгүй иргэдийн сонгууль зохион байгууллаа гэж үзэхэд бол тэр шаардлагад нийцэх хэмжээний бол төхөөрөмж ажиллах боломжгүй болчихсон гэдгийг бол мэргэжлийн байгууллагууд нь бол тогтоочихсон юм.

2-т бол Саранчулуун гишүүн асууж байна. Хүртээмж нэмэгдэж байгаа юу гэж. Манайх өмнө өнгөрсөн хугацааны сонгуулиудаа 3 мянган машинаар дандаа тоолж байсан бол хүртээмжийг 500 машинаар нэмэгдүүлж байгаа. Тэгж байж нөгөө бүх хэсгүүдэд хүртээмж нь нэмэгдэж, сонгуулийн санал тоолох машины бол хүрэлцээ 100 хувь хангагдана гэж үзэж байгаа. Одоо бид нар энэ дээрээ 1 ингээд солиод авчихвал дахиад 3 сонгуулийн цикл, 4 сонгуулийн циклд программаа шинэчлээд яваад байх боломж нь бол байгаа юм байна лээ. Тэгээд дэмжиж өгөхийг хүсье.

Ц.Сандаг-Очир: Гишүүд зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулж асуулт хариулт авч дууслаа. Миний тэр уншсан дээр хэрэгжих хугацаа 2026-26 он юм байна шүү. 2028 он гэж буруу уншсан байна. 2026 он юм байна. Ингээд Улсын Их Хурлын гишүүн Баярбаатарын гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 21 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 61,9 хувиар Улсын Их Хурлын гишүүн Баярбаатар гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Дараагийн санал Ариунзаяа гишүүн зарчмын зөрүүтэй саналынхаа томъёоллыг илүү тодорхой болгоод ирсэн гэж байна. Анхааралтай гишүүд ээ. Санал хураах гэж байна. Өөрсдийнхөө саналыг хураалгачхаад гараад явж болохгүй шүү. Одоо хэдхэн санал байна.

Төрийн албан хаагчдын өндөр насны тэтгэвэрт гарахад олгодог нэг удаагийн буцалтгүй тусламж болох 36 хүртэлх сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний тэтгэмжийн зардалд тусгагдсан санхүүжилтийг 178,089.9 сая төгрөгөөр нэмэгдүүлж, уг эх үүсвэрийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийн урсгал зардлын бараа, үйлчилгээний бусад зардлыг 178,089.9 сая төгрөгөөр бууруулах замаар бүрдүүлэх зөв үү. Ийм зарчмын зөрүүтэй санал гаргасан байна. Энэ санал дээр тайлбараа хэлэх үү. Ариунзаяа гишүүн.

А.Ариунзаяа: Манай гишүүд маань бас санал гаргаж байгааг би хүндэтгэн үзэж, Коп-той холбоотой зардлыг оролдохгүй байхыг хүсэж байгаа учраас би саналын томъёоллоо өөрчлөөд ороод ирлээ. Тэгээд ямар ч байсан хэдүүлээ төрийн албан хаагчдынхаа өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх хэрэгтэй. Тэгээд энэ саналыг дэмжиж өгөөрэй гэж хүсэж байна. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Улсын Их Хурлын гишүүн Ариунзаяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт гишүүд ээ, анхааралтай. 21 гишүүнээс 13 гишүүн дэмжиж, 61,9 хувиар Ариунзаяа гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдлээ.

Дараагийн зарчмын зөрүүтэй санал.

Төслийн 2 дугаар хавсралтын УТ2601100257 төслийн кодтой, төрийн албаны шинэчлэлийн хүрээнд төрийн бүтээмжийн нэгдсэн мэдээллийн систем /Улаанбаатар Сүхбаатар дүүрэг/ хэрэгжих хугацаа 2026-2027 он, төсөвт өртөг 3,506.6 сая төгрөг, 2026 онд санхүүжих дүн 1 тэрбум 578 сая төгрөг гэсэн төсөл, арга хэмжээг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу. Санал гаргасан гишүүд 1 нь ч байхгүй байна.

3 гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал гаргасан хүн нь 1 нь ч алга. Байвал хамаа алга. Тайлбарыг нь сонсмоор байна. Дэгээрээ байхгүй байна. Хасъя гэдгийг нь үү. 1,5 тэрбум төгрөг орж ирэх л юм байна хасчихвал, санал дэмжигдвэл. 3 гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Тэгээд эх үүсвэр бий болгох гээд байна шүү дээ. Уг нь бол. 21 гишүүнээс 8 гишүүн дэмжиж, 38,1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Дараагийн санал.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын даргын төсвийн багцын урсгал зардал дахь Төрийн шагнал, одон медалийн зардлыг 1,842.9 сая төгрөгөөр бууруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн С.Цэнгүүн, Ш.Бямбасүрэн, Ч.Лодойсамбуу.

Эхийн одонгийн мөнгийг хасах гэж байна шүү дээ. Тэр одон медаль хийх зардлыг нь. Зарчмын зөрүүтэй санал гаргасан 3 гишүүний саналыг дэмжье гэсэн томьёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 21 гишүүнээс 5 гишүүн дэмжиж, 23,8 хувиар Цэнгүүн, Бямбасүрэн, Лодойсамбуу нарын гаргасан зарчмын зөрүүтэй санал дэмжигдсэнгүй.

8 дахь санал.

Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцын урсгал зардал дахь Эрдэм шинжилгээ судалгааны ажлын зардлыг 204 тэрбумаар бууруулах гэсэн энэ зарчмын зөрүүтэй санал манай Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд байхгүй юм байна лээ.

Энийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо дээр хураалгах ёстой тийм үү. Бид нар бол эрхлэх асуудлын хүрээний асуудлаа л санал хураалгана.

Тэгээд сүүлчийн санал хураалт гишүүд ээ. Энэ нь өөрчлөгдсөн үү, өөрчлөгдөөгүй юу. Яг ингээд уншиж болох уу. Эх үүсвэрийг нь унших юм байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын багцын урсгал зардлаас 300.0 сая төгрөгийг бууруулж, Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлын төлбөр хураамжийг 300.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Пүрэвдорж.

Пүрэвдорж гишүүн гаргасан саналаа тайлбарлая.

Б.Пүрэвдорж: Энэ цагаатгах ажлын улсын комисс бол яг миний цэвэр удирдлага дор ажилладаг. Өнгөрсөн хугацаанд бол нийтдээ 3 жилийн өмнө гэхэд 18 тэрбум төгрөгийн төсөвтэй байсан. Өөрөөр хэлбэл энэ тодорхой нөхөн олговруудыг олгодог. Тийм учраас энэ олговрууд энэ жилийн хувьд бол маш цөөхөн байгаа. Тэгээд энэ байгууллагын хувьд тодорхой хэмжээний ажил явуулах ямар ч боломжгүй болсон ийм байгууллага байгаа. Нийтдээ 700 орчим сая төгрөгөөр л энэ бүх ажил нь явдаг ийм байгууллага. Тэгээд тэгтэл дээрээс нь нэмээд бүх ажлыг нь хасаад, тодорхой хэмжээний байр орны төлбөр төлөх тэр бүх зардлуудыг нь хасаад явчихсан учраас энэ зардлыг заавал тавихгүй бол энэ байгууллага өөрөө орон байргүй, дээрээс нь бас тодорхой хэмжээний үйлчилгээ, ажил хэрэг явуулах боломжгүй ийм болчихоод байгаа юм. Тийм учраас энэ 300 сая төгрөгөөр нэмэгдүүлэх энэ ажлыг та бүхэн дэмжиж шийдэж өгөөч.

Энэ Хууль зүй, дотоод хэргийн сайдын урсгал зардал бол маш их байдаг. Энэ Цагаатгах ажлын улсын комиссын энэ санал хураалт бол Хууль зүйн байнгын хороо дээр хураагдах хураагдах ёстой. Гэхдээ аль ч Байнгын хороо дээр бол энэ асуудлыг бол хураалгах боломж бий.

Тийм учраас энэ асуудлыг ... энэ чинь тодорхой хэмжээний тэр оффисын барилгын түрээс энэ тэр төлдөг байхгүй юу даа. Тэр төлбөрийг бүгдийг нь хасаад хаячихсан байхгүй юу даа. Тэр байгууллага чинь төрийн байгууллага ч гэсэн төрийн өмчийн аль нэг байгууллага дээр очиж байрладаг. Тэгээд тэндээсээ тодорхой төлбөр хураамж бас төлж байж, цаад талын Засгийн газрын байрнууд нь бас ашиглалтаа хийдэг ийм л юм байхгүй юу даа. Тийм учраас тэр ажлуудыг нь байхгүй хасаад хаячихсан байгаа.

Ц.Сандаг-Очир: Та сая хэлж байна. Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах салбарын ажил бол манай Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалахгүй, Хууль зүйн байнгын хороонд харьяалагддаг. Тэгэхээр сая яг өмнөх 8 дахь санал хураалтыг тэгээд явуулсангүй шүү дээ. Тэгэхээр бид нар эрхлэх асуудлынхаа хүрээний саналыг л хураалгана шүү дээ. Үгүй ээ, эрхлэх асуудлынхаа хүрээнд бид нар бол Төрийн байгуулалтын байнгын хороонд харьяалдаг байгууллагуудынхаа л төсвийн асуудлыг нэмж, хасах асуудал. Та Хууль зүй дээрээ саналаа гаргасан уу. Тэгээд хоцорчихсон гээд манайх руу оруулж ирж болохгүй.

Пүрэвдорж гишүүний гаргаж байгаа зарчмын зөрүүтэй саналыг Төрийн байгуулалтын байнгын хороо дээр хураалгаж болох уу, болохгүй юу. Энэ дээр хариулт өгөөдөх манай Байнгын хорооны ажлын албаныхан.

Ингэсэн байна. Аль алиндаа та буруу байна.

1-т Хууль зүйн байнгын хорооноосоо саналаа гаргахаа хоцорсон байна.

2-т манай ажлын албаныхан таны саналыг Хууль зүйн байнгын хороо руу одоо хуралдах гэж байна. Санал хураалт эхлээгүй байна гэж байна. Манай ажлын албаныхан Хууль зүйн байнгын хорооны эрхлэх асуудлынх нь хүрээ рүү шилжүүлээд өг. Пүрэвдорж гишүүний гаргасан саналыг. Тэгээд хэдүүлээ дэгээ зөрчихгүйгээр ингээд явъя. Болж байна уу.

Ингээд Монгол Улсын 2026 оны төсвийн тухай, Үндэсний баялгийн сангийн 2026 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүдээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Төсвийн байнгын хороонд танилцуулах Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн дарга танилцуулна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан хаасныг мэдэгдье. Хуралдаандаа идэвхтэй оролцсон гишүүдэд баярлалаа.

12.07 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ